



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/41/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: <a href="mailto:bunkhbatb@audit.gov.mn">bunkhbatb@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: <a href="mailto:tseenyama@audit.gov.mn">tseenyama@audit.gov.mn</a> Аудитор: Б.Цэрэнчимэд Утас: 88117644 Цахим хаяг: <a href="mailto:tserenchimedb@audit.gov.mn">tserenchimedb@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан.....	5
<b>2.1. Оршил .....</b>	<b>5</b>
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
<b>2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....</b>	<b>5</b>
<b>2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....</b>	<b>5</b>
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг, төлөвлөлтийн шатанд тооцсон 3722,9 мянган төгрөгөөр тооцож баталгаажуулав.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	9
<b>1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....</b>	<b>9</b>
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	10
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	11
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	13
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	14



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН АХМАД Г  
НАСТАНЫ АСРАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ТӨВИЙН ДАРГА Д.АМАРСАНАА ТАНАА

*Ауд. гэр. 21* № *1/156*

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г \_\_\_\_\_ Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\  
• 005020112

хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## 2.1. Оршил

Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч Д.Амарсанаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 2020 оны 02 дугаар сарын 18-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 27 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Монгол улсын засгийн газар, аймгийн ИТХ, Засаг даргаас тавьж буй хөтөлбөр зорилтыг хэрэгжүүлэх, сум, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах,

хууль ёсыг чандлан сахиулж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай хүргэхэд оршино” гэжээ.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

ХХҮЕГазрын даргын 2018 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А/174 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Асрамжийн төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох группын “Аcolous” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 33 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 186145,7 мянган төгрөгөөс тооцон 3722,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг, төлөвлөлтийн шатанд тооцсон 3722,9 мянган төгрөгөөр тооцож баталгаажуулав

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38141,3 мянган төгрөгөөр буюу 2,52 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага	2,234.96	-	(2,234.96)
Урьдчилгаа	-		-
Бараа материал	10,199.26	12,899.03	2,699.77
Үндсэн хөрөнгө	1,873,638.90	1,798,721.62	(74,917.28)
Хуримтлагдсан элэгдэл	(416,372.55)	(402,499.84)	13,872.71
Биет бус хөрөнгө	40,390.00	62,965.00	22,575.00
Хуримтлагдсан элэгдэл	(463.75)	(600.25)	(136.50)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,509,626.81</b>	<b>1,471,485.56</b>	<b>(38,141.25)</b>
Өр төлбөр	374.66	51.76	(322.90)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	66,316.36	88,891.36	22,575.00
Өмнөх үеийн үр дүн	1,285,265.68	1,285,265.68	-
Тайлант үеийн үр дүн		(60,393.36)	(60,393.36)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	157,670.11	157,670.11	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,509,626.81</b>	<b>1,471,485.56</b>	<b>(38,141.25)</b>

Авлага дансны үлдэгдэл буурсан нь АЖБИД ХХК дээр үүсгэсэн хүнсний материалын авлага 1034,9 мянган төгрөг, эрчим хүчний авлага 1200,0 мянган төгрөг. Нийт 2234,9 мянган төгрөгийн авлага барагдуулж, оны эцэст авлагагүй гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2699,7 мянган төгрөгөөр өссөн нь тухайн жилд аж ахуйн материал 10332,2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 7951,4 мянган төгрөгийн материал зарцуулж, материалын үлдэгдэл 2380,8 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Санхүүгийн тайланд аудит хийх явцад цаг хугацааны боломжгүйгээс шалтгаалж бараа материалын үлдэгдэл өмнөх оноос өссөн, ялангуяа аж ахуйн материал, хүнс, эмийн зарцуулалтад судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт өгөх боломж байгаагүй тул дараагийн аудитаар тодруулах шаардлагатай байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 52342,2 мянган төгрөг буурсан нь Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2019.01.31 -ны 18 дугаар тогтоол, 2019.06.13-ны 68 дугаар тогтоолуудаар 80290,6 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 322,9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлийг бүрэн барагдуулж, тайлант онд 56,7 мянган төгрөгийн өглөг үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1471485,5 мянган төгрөг болж өмнөх оноос 38141,3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант жилийн үр дүн 60393,3 мянга, өглөг 322,9 мянган төгрөгөөр тус тус буурч, шинээр 22575,0 мянган төгрөгийн газар орлогод авч Засгийн газрын сан нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн байна.

#### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 /80101, 80802/ хөтөлбөрт зориулан 119815,3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 119815,3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 119815,3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 116733,2 мянган төгрөг буюу 97,4 хувьтай байгаа бөгөөд зарцуулаагүй үлдсэн 3082,1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байгаа нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан, урсгал засварын хэмнэлт нөлөөлсөн байна.

**Нэмэлт төсөв:** Нэмэлт санхүүжилтийн дансаар 8098,9 мянган төгрөгийн орлого орсон байна. Энэ нь ХАХНХСайдын 2013 оны А/156 тогтоолоор батлагдсан журмын дагуу асрамжид хамрагдсан иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийн 30,0 хувийг нэмэлт санхүүжилтийн дансанд орлогоор бүргэж, байгууллагын даргын тушаалаар эмийн зардалд 3042,2 мянган төгрөг, хүнсэнд 1234,0 мянган төгрөг, хувцас хэрэгсэлд 327,0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварт 3493,8 мянган төгрөг тус тус зарцуулж, 1900,0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

#### 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 33 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 28 эрсдэл тодорхойлж, хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 51,7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 51,7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг санхүүгийн тайланд өглөгөөр залруулав.

#### 2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 136 мэдээллийг хугацаанд нь, 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, хугацаа болоогүй 2 мэдээллийг байршуулаагүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0

4	Сар бүр	3	36	33	3	0
5	Тухай бүр	8	96	84	12	0
	Нийт	27	151	136	15	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй, албан шаардлага өгөгдөөгүй, 3 заалт бүхий зөвлөмжийг хэрэгжүүлж, хариуг ХХҮГ-ын 2019.04.30-ны 255 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,434,220.02</b>	<b>12,899,030.02</b>
33	АВЛАГА	2,234,960.00	00.00
335	Бусад авлага	2,234,960.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	2,234,960.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>10,199,260.02</b>	<b>12,899,030.02</b>
354	Хангамжийн материал	10,199,260.02	12,899,030.02
35410	Бичиг хэргийн материал	60,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	10,139,260.00	12,520,060.00
35440	Түлш, шатах тослох материал	00.02	00.02
35460	Хүнсний материал	00.00	378,970.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,497,192,593.36</b>	<b>1,458,586,528.56</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,497,192,593.36	1,458,586,528.56
392	Биет хөрөнгө	1,457,266,343.36	1,396,221,778.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,510,299,558.00	1,507,858,938.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-157,126,192.01	-182,638,673.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	68,998,000.00	68,998,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-52,332,000.16	-60,665,000.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	181,310,029.38	113,753,023.85

39206	Хуримтлагдсан элэгдэл	-158,347,347.28	-107,334,294.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	113,031,309.00	108,111,656.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-48,567,013.57	-51,861,870.58
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>39,926,250.00</b>	<b>62,364,750.00</b>
39301	Програм хангамж	1,050,000.00	1,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-463,750.00	-600,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	39,340,000.00	61,915,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,509,626,813.38</b>	<b>1,471,485,558.58</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>374,661.00</b>	<b>51,763.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>374,661.00</b>	<b>51,763.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>374,661.00</b>	<b>51,763.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	185,320.00	51,763.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>189,341.00</b>	<b>00.00</b>
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	189,341.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,509,252,152.38</b>	<b>1,471,433,795.58</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,509,252,152.38</b>	<b>1,471,433,795.58</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	66,316,360.00	88,891,360.00
51101	Өмч: - төрийн	66,316,360.00	88,891,360.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,285,265,682.82</b>	<b>1,224,872,326.02</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,285,265,682.82	1,285,265,682.82
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-60,393,356.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	157,670,109.56	157,670,109.56
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,509,626,813.38</b>	<b>1,471,485,558.58</b>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>173,624,643.00</b>	<b>127,914,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>61,052,285.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>61,052,285.00</b>	<b>00.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	60,713,285.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	60,713,285.00	00.00
120009	Бусад орлого	339,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>112,572,358.00</b>	<b>127,914,200.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>14,149,958.00</b>	<b>8,098,900.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,149,958.00	8,098,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>98,422,400.00</b>	<b>119,815,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	98,422,400.00	119,815,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>179,011,223.82</b>	<b>186,197,510.96</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>179,011,223.82</b>	<b>186,197,510.96</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>178,551,893.82</b>	<b>182,113,483.96</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>50,062,557.60</b>	<b>60,528,280.00</b>
210101	Үндсэн цалин	48,063,057.60	60,528,280.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,999,500.00	00.00

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>5,579,607.40</b>	<b>7,799,889.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,732,043.10	5,314,881.00
210202	Тэтгэмжийн даатгал	466,586.60	607,859.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	417,660.50	539,866.00
210204	Ажилгүйдлийн даатгал	97,958.00	121,571.00
210205	Эрүүл мэндийн даатгал	865,359.20	1,215,712.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>17,068,223.16</b>	<b>14,657,401.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,668,787.00	2,578,215.00
210302	Түлш, халаалт	13,931,670.16	10,639,650.00
210303	Цэвэр, бохир ус	1,467,766.00	1,439,536.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,566,722.00</b>	<b>2,349,400.00</b>
210401	Бичиг хэрэг	513,000.00	645,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,338,690.00	150,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,715,032.00	1,554,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>28,368,012.00</b>	<b>25,185,695.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	802,300.00	1,360,600.00
210502	Хоол, хүнс	23,380,712.00	20,835,095.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,185,000.00	2,990,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>114,060.00</b>	<b>1,476,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	65,000.00	61,700.00
210604	Урсгал засвар	49,060.00	1,414,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,924,530.00</b>	<b>5,672,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,924,530.00	5,552,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	120,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>64,868,181.66</b>	<b>64,444,418.96</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64,868,181.66	64,444,418.96
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>459,330.00</b>	<b>4,084,027.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>459,330.00</b>	<b>3,084,027.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	459,330.00	3,084,027.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-5,386,580.82</b>	<b>-58,283,310.96</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>2,110,045.84</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,110,045.84
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-2,110,045.84</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-5,386,580.82</b>	<b>-60,393,356.80</b>

#### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>112,911,358.00</b>	<b>127,914,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>339,000.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>339,000.00</b>	<b>00.00</b>

120009	Бусад орлого	339,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>112,572,358.00</b>	<b>127,914,200.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>14,149,958.00</b>	<b>8,098,900.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,149,958.00	8,098,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>98,422,400.00</b>	<b>119,815,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	98,422,400.00	119,815,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>112,911,358.00</b>	<b>122,540,800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>112,911,358.00</b>	<b>122,540,800.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>112,452,028.00</b>	<b>118,456,773.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>49,256,558.00</b>	<b>60,941,315.00</b>
210101	Үндсэн цалин	48,190,058.00	60,941,315.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,066,500.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>6,514,893.00</b>	<b>7,709,752.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	5,560,594.70	5,216,758.20
210202	Тэтгэмжийн даатгал	159,920.00	506,721.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	226,822.90	590,754.60
210204	Ажилгүйдлийн даатгал	47,715.00	232,938.20
210205	Эрүүл мэндийн даатгал	519,840.40	1,162,579.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,468,223.00</b>	<b>13,457,401.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,868,787.00	1,378,215.00
210302	Түлш, халаалт	10,131,670.00	10,639,650.00
210303	Цэвэр, бохир ус	1,467,766.00	1,439,536.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,376,490.00</b>	<b>2,289,450.00</b>
210401	Бичиг хэрэг	366,500.00	585,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,338,690.00	150,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,671,300.00	1,554,050.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,310,034.00</b>	<b>23,513,655.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	302,300.00	365,100.00
210502	Хоол, хүнс	18,357,607.00	20,158,555.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,650,127.00	2,990,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>691,910.00</b>	<b>2,757,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	607,500.00	766,700.00
210604	Урсгал засвар	84,410.00	1,990,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,833,920.00</b>	<b>7,788,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,233,920.00	7,668,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	120,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>459,330.00</b>	<b>4,084,027.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>459,330.00</b>	<b>3,084,027.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	459,330.00	3,084,027.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>5,373,400.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>5,373,400.00</b>

22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>5,373,400.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	5,373,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	5,373,400.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-5,373,400.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа:Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,976,360.00	83,268,817.20	1,291,952,958.02	1,402,198,135.22
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,976,360.00	83,268,817.20	1,291,952,958.02	1,402,198,135.22
Тайлант үеийн үр дүн	39,340,000.00	00.00	-5,386,580.82	33,953,419.18
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	66,316,360.00	157,670,109.56	1,285,265,682.82	1,509,252,152.38
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	66,316,360.00	157,670,109.56	1,285,265,682.82	1,509,252,152.38
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	66,316,360.00	157,670,109.56	1,285,265,682.82	1,509,252,152.38
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	22,575,000.00	00.00	00.00	22,575,000.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-60,393,356.80	-60,393,356.80
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	88,891,360.00	157,670,109.56	1,224,872,326.02	1,471,433,795.58

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа:Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	119,815,300.00	116,733,173.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	119,815,300.00	116,733,173.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	118,815,300.00	115,733,173.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	60,941,400.00	60,941,315.00
210101	Үндсэн цалин	60,941,400.00	60,941,315.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	8,318,600.00	7,709,752.00
210201	Тэтгэврийн даатгал	5,656,600.00	5,216,758.20
210202	Тэтгэмжийн даатгал	665,500.00	506,721.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	532,400.00	590,754.60

210204	Ажилгүйдлийн даатгал	133,100.00	232,938.20
210205	Эрүүл мэндийн даатгал	1,331,000.00	1,162,579.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>15,001,800.00</b>	<b>13,457,401.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,975,900.00	1,378,215.00
210302	Түлш, халаалт	11,588,900.00	10,639,650.00
210303	Цэвэр, бохир ус	1,437,000.00	1,439,536.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,294,000.00</b>	<b>2,289,450.00</b>
210401	Бичиг хэрэг	307,400.00	585,000.00
210402	Тээвэр, шатахуун	320,500.00	150,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	215,400.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,450,700.00	1,554,050.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,516,500.00</b>	<b>23,513,655.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	366,300.00	365,100.00
210502	Хоол, хүнс	20,158,600.00	20,158,555.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,991,600.00	2,990,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,443,000.00</b>	<b>7,701,600.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	336,600.00	3,211,100.00
210604	Урсгал засвар	8,106,400.00	4,490,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>300,000.00</b>	<b>120,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	120,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1000000.00</b>	<b>1000000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>119,815,300.00</b>	<b>116,733,173.00</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>119,815,300.00</b>	<b>116,733,173.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	119,815,300.00	116,733,173.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>10</b>	<b>10</b>
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	03	03
620003	Үйлчлэх ажилтан	06	06

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: Баянхонгор аймгийн Асрамжийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан


/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	14149958.00	8,098,900.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	14149958.00	8,098,900.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	14149958.00	8,098,900.00
2105	<b>Нормативт зардал</b>		4,603,200.00


210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		3,042,200.00
210502	Хоол, хүнс		1,234,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		327,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>3,493,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,071,800.00
210604	Урсгал засвар		2,422,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14149958.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14149958.00	00.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		1,900,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	14149958.00	8098900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	14149958.00	8,098,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14149958.00	8,098,900.00

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:  Б.ЦЭРЭНЧИМЭД 2020.02.21

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЭНЯМ 2020.02.21

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ 2020.02.21

